



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Булган аймгийн Засаг даргын Тамгын газар

Нийгмийн бодлогын хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Булган аймаг, Булган сум, 5-р баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг ханган, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын бүлгүүдийн чиглэлээр батлагдсан бодлого шийдвэрийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, орлогыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах;
2. Хүн амын амьжиргааг дэмжих, нийгмийн хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
3. Аймгийн Засаг даргын холбогдох яам, агентлаг, сум байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, тайлан мэдээг нэгтгэн, удирдлагыг мэдээллээр хангах;
4. Нэгжийн үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
5. Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих;	Хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин буурсан байна.	Г
	2. Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох, богино, дунд хугацааны болон хэтийн зорилтыг боловсруулах;	Хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин буурсан байна.	Г
	3. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг бодлогын удирдамж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих;	Хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин буурсан байна.	Г
	4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эх үүсвэр, төсөв, тусгай зориулалтын сан, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтыг хийх, зарцуулалтад хяналт тавих, үнэлж дүгнэх;	Хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин буурсан байна.	Г
	5. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажлын байраар хангах чиглэлээр тусгайлан бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх;	Зорилтот бүлгийн иргэдийн эрхлэлт байна.	бүлгийн хөдөлмөр нэмэгдсэн



<p>6.Хөдөлмөрийн бирж, гадаадад ажиллах хүч илгээх болон гадаадаас ажиллах хүч авахад зуучлах байгууллагатай хамтран иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх;</p>	<p>Гадаадад хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин буурсан байна.</p>	Г
<p>7.Хөдөлмөрийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран малчин залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;</p>	<p>Хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.</p>	Г
<p>8.Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавихад төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах, хөдөлмөр эрхлэх болон бусад чиглэлээр байгуулагдсан аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнд Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл оролцуулан, хамтран ажиллах;</p>	<p>Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	Г
<p>9.Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг 2 жил тутамд байгуулан, тайлан мэдээг гаргах, түншлэлийн хэлбэрээр асуудал хэлэлцүүлэх, жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажилд хяналт тавих;</p>	<p>Гэрээний хэрэгжилт хангагдсан байна.</p>	Г
<p>10.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн нутаг дэвсгэртээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал эрхэлсэн ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулах;</p>	<p>Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	Г
<p>11.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн болон иргэдийн Нийтийн хурал, дээд шатны Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг</p>	<p>Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	Г



	зохион байгуулах.		
2 дугаар зорилтын хүрээнд	1.Нийгмийн халамжийн болон асрамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	2.Нийгмийн хамгааллын чиглэлээр нийгмийн бүлгүүдэд чиглэсэн аймгийн бодлого шийдвэрүүдийг боловсруулан хэрэгжилтэд хяналт тавих;	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	3.Хүн амын амьжиргааны түвшин тогтоох судалгааг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулахад хяналт тавьж, үр дүнг тооцох, бодлого шийдвэр гарган холбогдох дээд байгууллагаар шийдвэрлүүлэх;	Хүн амын амьжиргааны түвшин дээшилсэн байна.	Г
	4.Зорилтот өрхийн нөхцөл байдлыг үнэлэн өрхийн гишүүдийн хэрэгцээ, чадавх, боломжийг нь тодорхойлж, зорилтот өрх бүрд амьжиргааг нь дээшлүүлэх хөгжлийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх;	Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааны түвшин дээшилсэн байна.	Г
	5.Зорилтот өрхийн гишүүдийг чадавхжуулах, эерэг дадал, хэвшил төлөвшүүлэх, өрхийн гишүүдийн нийгэм, гэр бүл, хөршийн харилцаагаа сайжруулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа, сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө өгөх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;	Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааны түвшин дээшилсэн байна.	Г
	6.Хүн амын бүлгүүдийн нарийвчилсан судалгааг гаргаж, нэгдсэн сан үүсгэх, нийгмийн халамжийн хуулийн дагуу хөнгөлөлт, тэтгэвэр, тэтгэмжийн олголтод хяналт тавих, энэ чиглэлээр ирсэн санал гомдлыг шийдвэрлэх;	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	7.Зорилтот өрхийг хөгжүүлэх,	Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааны	Г



<p>хамгаалахад чиглэсэн сайн дурын аян, үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгыг дэмжин урамшуулах;</p>	<p>түвшин дээшилсэн байна.</p>	
<p>8.Хүн амын бүлгүүдийн уулзалт зөвлөгөөн, тэмдэглэлт өдөр, сургалт мэдээллийн арга хэмжээг сар тутам зохион байгуулах, үр дүнг тооцох;</p>	<p>Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	Г
<p>9.Ахмад настны амьжиргаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах, ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр боловсруулах, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ахмад настны талаарх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;</p>	<p>Ахмад настнууд хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөл бүрдсэн байна.</p>	Г
<p>10.Ахмад настныг судалж бүртгэх, хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж тогтоох болон дэмжлэг, тусламж үзүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгуулах;</p>	<p>Ахмад настнууд хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөл бүрдсэн байна.</p>	Г
<p>11.Ахмад настныг дэмжих талаар авах арга хэмжээ, зарцуулах төсвийн санал боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, энэ талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах саналыг халамжийн байгууллагад уламжлах;</p>	<p>Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	Г



<p>12.Аймагт ахмадын ордон, сум, дүүрэгт ахмадын өргөө, танхим, төв байгуулж ажиллуулахад шаардагдах хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт жил бүр тусгах;</p>	<p>Ахмад настныг дэмжих орчин, нөхцөл бүрдсэн байна.</p>	<p>Г</p>
<p>13.Ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх;</p>	<p>Нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдах шаардлагатай ахмад настуудыг бүрэн хамруулсан байна.</p>	<p>Г</p>
<p>14.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн нөхөн сэргээх нийгэмшүүлэх төвийг байгуулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах судалгаа, тооцоог гарган төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэх;</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцөл бүрдсэн байна.</p>	<p>Г</p>
<p>15.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах аймгийн салбар хороо, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын салбар комиссыг байгуулан үйл ажиллагаанд нь хяналт тавих;</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд бүрэн хамруулсан байна.</p>	<p>Г</p>
<p>16.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг урлаг, спорт, соёл олон нийтийн арга хэмжээнд татан оролцуулах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах, удирдлага, мэргэжил арга зүйгээр хангах;</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо нэмэгдсэн байна.</p>	<p>Г</p>
<p>17.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийг сайжруулахад хяналт тавих ажлын хэсгийг томилон, мэдээ тайланг авч нэгтгэх;</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдсэн байна.</p>	<p>Г</p>
<p>18.Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн нэгдсэн санг</p>	<p>Мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн байна.</p>	<p>Г</p>



бүрдүүлэх, судалгаа хийх;		
19.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн уулзалт, хэлэлцүүлэг, чуулган зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулах;	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдсэн байна.	Г
20.Малчид болон албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлж, сургалт, мэдээллийн ажлыг тогтмолжуулахад анхаарч мэргэжил арга зүйгээр хангах;	Нийгмийн даатгалд сайн дураар хамрагдалт нэмэгдсэн байна.	Г
21.Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, зарлагын мэдээг сар бүр авч хянах, аж ахуйн нэгж байгууллагын өр авлагыг бууруулах чиглэлээр албан даалгавар гарган хэрэгжилтэд хяналт тавих;	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
22.Аймгийн Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж, тайлан мэдээг сонсох, үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйгээр хангах;	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
23.Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд хөнгөлөлттэй олгож байгаа эмийн жагсаалт, олгох журмын хэрэгжилтэд хяналт тавих;	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	
24.Эрүүл мэндийн газартай хамтран Хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх нөхөн сэргээх арга хэмжээг нэгдсэн бодлого зохицуулалттай явуулахад мэргэжил арга зүйгээр хангах;	Хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдийн тоо буурсан байна.	Г
25.Зорилтод өрхийн гишүүдийг нийгмийн даатгалын үйлчилгээнд хамруулах, эрүүл мэндийн үйлчилгээ авах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;	Зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн даатгалд хамрагдалт нэмэгдсэн байна.	Г



	26. Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт мэдээллийн ажлыг бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдол тасралтгүй буурсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Аймгийн Засаг дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай байгуулах гэрээний саналыг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх, хагас бүтэн жилээр гэрээний хэрэгжилтийг тооцон тайлагнах, хяналт тавих;	Гэрээний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2. Сумдын Засаг дарга нарын аймгийн Засаг даргатай байгуулах гэрээний төслийг боловсруулан, хэрэгжилтэд хяналт тавьж, жилийн эцсийн тайлан мэдээг нэгтгэн дүгнэх;	Гэрээний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	3. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын аймгийн Засаг даргатай байгуулах гэрээний төслийг боловсруулан холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн, жилийн эцэст дүгнэх ажлыг зохион байгуулах;	Гэрээний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	4. Салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа Засгийн үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөр, үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэр, дүрэм журмын хэрэгжилтийг ханган хагас бүтэн жилээр тайлан мэдээг гарган холбогдох байгууллагад хүргүүлэх;	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	5. Салбарын яам, агентлагийн зүгээс зохион байгуулж байгаа сургалт, зөвлөгөөн, чуулганд оролцох, сум орон нутгийн салбарын үйл ажиллагаатай танилцах, зөвлөн туслах;	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байна.	Г



	6.Олон нийтийг хамарсан хурал, зөвлөгөөн, уулзалт, уралдаан тэмцээн, урлаг соёлын арга хэмжээнд мэргэшил арга зүйгээр ханган ажиллах.	Мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Тушаал шийдвэр, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Г
	2.Нэгжийн даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, арга хэмжээний биелэлтийг хангаж, тогтоосон хугацаанд нь тайлагнах, үр дүнг үнэлж дүгнүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан, үнэлгээ.	Г
	3.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад хэлтсийн даргад дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнүүдэд чиглэл өгөх, хянах.	Үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад дэмжлэг үзүүлнэ.	Г,Х
5 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм журам, байгууллагын дотоод журам, бусад төрийн албаны стандартыг мөрдөж хэрэгжүүлэх;	Төрийн албаны тухай хууль болон бусад стандарт дүрэм, журмыг зөрчөөгүйг нотлох дүгнэлт гаргасан байна.	Г
	2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах;	Эрх бүхий албан тушаалтанд ХАСХОМ-ийг өгсөн байдал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.	Г
	3.Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх, байгууллага, нэгжийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах;	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байх.	Г
	4.Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол ур	Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, боловсрол ур	Г



чадвараа дээшлүүлэх.	тогтмол	чадвараа дээшлүүлэн ажилласан байна.	тогтмол
II. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - нийгмийн хамгаалал /092/ - хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй /1022/ - эрх зүй /0421/ - боловсрол \011\ - мэдээллийн систем \061203\ - бизнес ба удирдахуй \041\ - байгалийн шинжлэх ухаан, математик, статистик \05\ - нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан /031/ 		
Мэргэшил	Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх ур чадвар	<ul style="list-style-type: none"> - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх ; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, - нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад. 	
	Асуудал шийдвэрлэх ур чадвар	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - албан үүргээ ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид шийдвэрлэх; - хууль, эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бүтээлч, санаачилгатай ажиллах; - бусад. 	
	Багаар ажиллах чадвар	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - хамт олонч сэтгэлгээтэй, зөрөг уур амьсгалыг дэмждэг байх; - нээлттэй шударга байх; - бусад. 	
	Бусад ур чадвар	<ul style="list-style-type: none"> - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - зарчимч, тууштай ажил хэрэгч байх, - шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; 	



	<ul style="list-style-type: none"> -албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; -компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; -кирилл болон үндэсний бичгээр албан бичиг боловсруулах чадвартай байх; -англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.
--	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект</u> 1. Холбогдох яам, агентлаг; 2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны холбогдох албан тушаалтан; 3. Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэн; 4. Сумдын болон багийн Засаг дарга; 5. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн бусад байгууллагууд; 6. Иргэн, хуулийн этгээд.
---	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА/Д. ЭРДЭНЭБИЛЭГ/ 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо 22 05 11 Дугаар 339

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:
 БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2022.06.17

Дугаар: 5199

ДАРГА /Д. АЛТАНШАГАЙ/
 (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)
 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр

